

Булган-Ундарга ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

2018 оны 04-р сарын 27 өдөр

№ 18/02

Булган хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 27-ний өдөр өөрийн байранд болов. Хурал 11:00 цагаас эхэлж ТУЗ-ийн даргыг түр орлон гүйцэтгэгч Б.Байгалмаа даргалан явуулав.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигч:

- Б.Байгалмаа /22528 ширхэг хувьцаа эзэмшигч/
- Д.Амгалан /49001 ширхэг хувьцаа эзэмшигч/
- Б.Төгсбуянд /18985 ширхэг хувьцаа эзэмшигч/

нар оролцож, ирц 80.0% тай байв. Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дах заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. ТУЗ-н ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах
3. ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлагат нэр дэвшигчийн танилцуулж батлах
4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх тогтоолын төсөлүүд

Хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд ТУЗ-ийн хийсэн дүгнэлтийг ТУЗ-ийн даргыг түр орлон гүйцэтгэгч Б.Байгалмаа танилцуулж, дараах нэмэлт тайлбар мэдээллийг хийв.

Өнгөрсөн жил компанид хүнд гарз тохиосон жил байлаа. Бид компанийн тухай хууль болон дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаараа гүйцэтгэх захирлыг томилон ажиллуулж цаашид компанийн үйл ажиллагааг авч явах ёстой. Компани маань 1963 онд байгуулагдан 1993 онд хувьчлагдсан. 1998 онд шинэчлэгдэн зохион байгуулагдаж 55 жил үйл ажиллагаа явуулж иржээ. Гэвч бид сүүлийн жилүүдэд доривтой ажил үйлчилгээ явуулсангүй цаашид яах талаараа ярилцаж тохиролцох хэрэгтэй байгаа хувьцаа эзэмшигчид саналаа тодорхой хэлээрэй.

Б.Байгалмаа миний санал: өнгөрсөн жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн гүйцэтгэх захирлаар Б.Төгсбуянг сонгосон мөн 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Захирал /хувьцаа эзэмшигч/ Ц.Батаа нь өөрийн нэг бүр нь 100 төгрөгийн үнэ бүхий 22527 ширхэг хувьцааг Б. Төгсбуянд Бэлэглэлийн болон эрх шилжүүлэх гэрээгээр тус тус шилжүүлсэн боловч тухайн үед ажил явдал гарсан тул бид хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүй хугацаа алдсан байсан. Бид энэ ээлжит хурлаар дээрх асуудалыг дахин хэлэлцэж батлах хэрэгтэй байна.

Гишүүдийн санал дүгнэлт Д.Амгалан

Миний хувьд татгалзах зүйл байхгүй. Цаашид ер нь би компанийг өөр дээрээ шилжүүлж авах саналтай байгаа гэхдээ та хэд дээр байгаа хувьцааг худалдан авах санхүүгийн боломж одоогоор байхгүй байна. санхүүгийн асуудал шийдэгдэж та хэдийн хувьцааг худалдан авсаны

дараа хөрөнгө хуваарилах, нэр шилжүүлэх асуудал хурлаар яригдана. Энэ онд чацарганы талбайгаа түшиглэж төсөл хөтөлбөрт хамрагдах бодолтой байна.

Байгалмаа: Хөрөнгө хуваарилах асуудлыг хувьцаа худалдан авсны дараа шийдвэрлэхийг дэмжиж байгаа.

Гишүүдийн санал дүгнэлт Б.Төгсбуян надад 3 санал байна

1. Компанийн тухай хуулийн 77.5-д заасны дагуу ТУЗ-ийн даргыг нөхөн сонгох учиртай. Иймд ТУЗ-ийн даргаар Б.Байгалмааг, ТУЗ-ийн гишүүнээр Б.Төгсбуян тус тус нэр дэвшүүлж байна.
2. Урьд жилүүдэд Компани маань доривтой үйл ажиллагаа явуулаагүй Компанийн өр зээлийг дарж барагдуулах зорилгоор ашиглагдаагүй хөрөнгө газар талбай, барилга, машин техник хэрэгсэлийг зарж борлуулсан байдаг мөн ажилд чын цалинд ч техник хэрэгсэлийг шилжүүлсэн байна мөн эвдэрч явахад больсон маяг, маз зэрэг машинуудыг сэлбэсэн байна. Эдгээр хөрөнгүүдийг акталж, данснаас хасах хэрэгтэй байна. Одоо үлдсэн өр зээлийн бид бүгд мэдэж байгаа.
3. Компанийн эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт орсон, мөн санхүүгийн зохицуулах хорооноос өөрчлөлт орсон хуулийн заалтын дагуу дүрмэнд өөрчлөлт оруулах тухай мэдэгдсэний дагуу компанийн дүрмийг шинэчлэн өөрчлөх шаардлага гараад байна.

Д.Амгалан, Байгалмаа дэмжиж байна татгалзах зүйл байхгүй ээ

Хэлцэх асуудалтай холбоотой өөр санал дүгнэлт байна уу?

Санал дүгнэлт байсангүй.

Санал хураалт явагдав.

Хурлаас шийдвэрлэсэн нь:

1. Компанийн 2017 оны санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийг зөвшөөрч батлахаар тогтов.
2. Хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг олгох боломжгүй гэж үзэв.
3. ТУЗ-ийн даргаар Б.Байгалмааг сонгов.
4. Гүйцэтгэх захирлаар Б.Төгсбуянг томилов мөн бэлэглэлийн гэрээгээр шилжүүлэн авсан 22527 ширхэг хувьцааг Б.Төгсбуяны нэр дээр шилжүүлэн хуулийн хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлэн компанийн дүрмд өөрчлөлт оруулахаар болов.
5. Компанийн ТУЗ-ийн гишүүнээр Б.Дэлгэмөрөнг сонгов.
6. Компанийн дүрмийг шинэчлэн өөрчлөхөөр болов.

Хурал 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 13 цаг 00 минутанд дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:



Б.ОТГОНЖАРГАЛ

Б.БАЙГАЛМАА

Д.АМГАЛАН

Б.ТӨГСБУЯН